

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/45

Арвайхээр

Г Эмнэлгийн болон эмнэлгийн бус нөхцөлд эндсэн  
тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл,  
амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.13 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны "Тав хүртэлх насны хүүхдийн эмнэлгийн болон эмнэлгийн бус нөхцөлд эндсэн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх тухай" А/503 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Эмнэлгийн нөхцөлд эндсэн тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх журам"-ыг нэгдүгээр, "Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг хэлэлцэх журам"-ыг хоёрдугаар, "Магадлан хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүн, гүйцэтгэх үүрэг"-ийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс(Ю.Ичинноров)-т даалгасугай.

Гурав. Тушаалыг мөрдөж ажиллахыг төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын захирал, дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Магадлан хэлэлцэх хурлаас гарсан шийдвэрийн гүйцэтгэлд хяналт тавьж, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Оюунтуяа), Хяналт шинжилгээ-Үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Я.Жаргал) нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны  
11 сарын 25 өдрийн 4/4 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт

ЙЮЕДУУ7

## ЭМНЭЛГИЙН НӨХЦӨЛД ЭНДСЭН ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, АМЬГҮЙ ТӨРӨЛТИЙГ МАГАДЛАН ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ

Нэг: Ерөнхий зүйл

Хүүхдийн эндэгдлийг магадлан хэлэлцэх зөвлөлийн хурал нь эмнэлгийн нөхцөлд эндсэн тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийн тохиолдол бүрт тусламж үйлчилгээг чанартай, зөв үзүүлсэн эсэхийг хянаж, хэлэлцэн, үнэлэлт, дүгнэлт өгөх үйл ажиллагаа юм.

Хоёр: Зорилго

Эмнэлгийн нөхцөлд эндсэн тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтөд нөлөөлсөн шалтгааныг магадлан хэлэлцэж, дүн шинжилгээ хийж, алдаа дутагдлыг давтагдахаас сэргийлэх, цаашид авах арга хэмжээг төлөвлөх үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

Гурав: Магадлан хэлэлцэх зөвлөлийн үйл ажиллагаа

3.1. Эрүүл мэндийн байгууллагын шатлал бүрт / Хархорин сумын НЭ, сум, өрхийн ЭМТ, хувийн хэвшил/ эмнэлэгт эндсэн тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийн тохиолдлыг эмгэг судлалын шинжилгээнд оруулж, дүгнэлт гарснаар эмнэлзүйн хурлыг (дээд шатны байгууллагатай зөвшилцөн холбогдох мэргэжилтний төлөөллийг оролцуулан) тухай бүрт нь хийж, материалыг аймгийн Эрүүл мэндийн газарт ажлын 3 хоногийн дотор цаасан болон цахим хэлбэрээр илгээнэ. БОЭТөв нь байгууллагад суурилсан эмнэлзүйн хурлыг улиралд нэг удаа удирдах дээд байгууллагаас холбогдох төлөөлөл, холбогдох сум өрхийн эмч нарыг оролцуулан зохион байгуулна.

3.2. Аймгийн эрүүл мэндийн газар нь тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх зөвлөлийн хурлыг улиралд 1 удаа хийнэ.

3.3. Эндэгдэл бүхий сум, өрх ЭМТ-үүд, хувийн хэвшлийн эмнэлэг нь өөрийн байгууллагад суурилсан эмнэлзүй, эмгэг судлалын хурлын удирдамж, зарыг гарган, хурал хийхээс ажлын 5 хоногийн өмнө шүүмж хийлгэх баримт материалуудыг хүүхдийн болон эх барих эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэнд нууцлалын зэргийг чанадлан хүргүүлсэн байна. ЭМГ-ын мэргэжилтнүүд нь шүүмж хийлгэх эмч нарын хуваарь гарган хуралд бэлтгэн удирдлага аргагүйгээр ханган ажиллана. БОЭТ-ийн хувьд эмнэлзүй, эмгэг судлалын хурлын удирдамж, зарыг гарган чанарын менежер холбогдох анхан шатны баримт бичгүүдийг тэмдэглэл хөтлөн дүн бүртгэлээс хүлээн авч, шүүмж хийлгэх эмчид хүлээлгэн өгч хурлын бэлтгэлийг хангуулна.

3.4. Зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ.



- Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлийг магадлан хэлэлцэж, дүгнэлт гаргана;
- Нөлөөлсөн хожимдлыг тодорхойлж, бууруулах талаар шийдвэр гаргана;
- Оношилгоо, эмчилгээтэй холбоотой сургамж, дүгнэлт хийж, зөвлөмж гаргана;
- Дүгнэлтэд үндэслэн асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга замыг тогтоож, цаашид зохион байгуулах ажлыг төлөвлөнө;
- Өмнө нь гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг үнэлнэ;
- 


3.5. Эмнэлзүй, эмгэг судлалын хурал хийхэд дараахь бичиг баримтыг бүрдүүлсэн байна.

- Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр
- 2 хүртэлх насны хүүхэд бол эхийн жирэмсний хяналтын карт
- Хүүхдийн өвчний цогц менежментийн үзлэгийн маягт
- Хүүхдийн диспансерийн хяналтын карт
- Амбулаторийн карт, цахим бүртгэл
- Хүүхдийн өсөлт, хөгжлийн хэмжилтийн бүртгэл
- Шаардлагатай тохиолдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч байсан холбогдох бусад материалууд (яаралтай тусламжийн хуудас, төрөлтийн, нярайн болон өвчний түүхийн хуулбар)
- Эмгэг судлалын дүгнэлт

3.6. Эрүүл мэндийн газар нь харъяа эрүүл мэндийн байгууллагуудын тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг улирал бүр хэлэлцэж, хурлын тэмдэглэл, зөвлөмж, шийдвэрийг 2 хувиан, хурлаас хойш ажлын 7 хоногийн дотор ЭМЯ-ны Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөл Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ)-ийн Тандалт судалгааны албанд албан бичгийн хамт хүргүүлнэ.

3.7. Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгооны төвийн чанарын албанаас улирал тутамд зөвлөмж гарган өрх, сумын ЭМТ, хувийн хэвшлийн байгууллагуудад хүргэн хэрэгжилтийг хангуулан ажиллана.

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны  
11 сарын 25 өдрийн 4/15 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт



## ЭМНЭЛГИЙН БУС НӨХЦӨЛД ЭНДСЭН ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ

Нэг: Ерөнхий зүйл

Хүүхдийн эндэгдлийг магадлан хэлэлцэх зөвлөлийн хурал нь эмнэлгийн бус нөхцөлд эндсэн тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийн тохиолдол бүрт тусламж үйлчилгээг чанартай, шуурхай үзүүлсэн эсэхийг хянаж, хэлэлцэн, үнэлэлт, дүгнэлт өгөх, шалтгаан нөхцлийг тогтоох үйл ажиллагаа юм.

Хоёр: Зорилго

Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтөд нөлөөлсөн шалтгааныг магадлан хэлэлцэж, дүн шинжилгээ хийж, алдаа дутагдлыг давтагдахаас сэргийлэх, нөхцөл шалтгааныг тодорхойлон цаашид авах арга хэмжээг төлөвлөх үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

Гурав. Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг мэдээлэх

- 3.1. Түргэн тусламжийн төвийн дуудлагаар очсон буюу анх мэдсэн эмч эмнэлгийн бус нөхцөлд эндсэн тав хүртэлх насны хүүхдийн тохиолдол бүрийг байгууллагын удирдлагад мэдээлж, тухайн байгууллагын удирдлага Эрүүл мэндийн газрын хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, статистикч их эмчид мэдэгдэнэ.
- 3.2. Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тохиолдол бүрийг 7 хоногийн Мягмар гараг бүрт ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгааны албанд сар бүрийн 2-3-нд статистик мэдээллийн урсгалын дагуу мэдээлнэ.
- 3.3. Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн нас барагтыг ЭМС-ын 611 дүгээр тушаалын маягтаар мэдээлнэ.

Дөрөв . Эмгэг судлалын шинжилгээнд оруулах

- 4.1. Цогцост анхны үзлэг хийсэн эмч гадны нөлөө байгаа эсэхэд дүгнэлт өгнө.
- 4.2. Тухайн эмч эндсэн хүүхэдтэй холбоотой эрүүл мэндийн бичиг баримтыг ар гэрийнхнээс нь авч, холбогдох байгууллага (өрх, сумын эрүүл мэндийн төв...гэх мэт)-д авч, тэмдэглэл үйлдэнэ.
- 4.3. Тухайн тохиолдол нь гадны нөлөөтэй байвал цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ, гадны нөлөөгүй гэж үзсэн тохиолдолд оршин буй нутаг дэвсгэрийн эмнэлгийн байгууллагын цогцос хадгалах газарт түргэн тусламжийн төвийн машинаар зөөвөрлөн хүргээд дуудлага өгч, эмгэг судлалын шинжилгээг хийлгүүлнэ
- 4.4. Тухайн тохиолдол нь гадны нөлөөгүй бол эмгэг судлалын шинжилгээг эмгэг



судлаач эмч хийх ба гадны шалтгааны улмаас нас барсан, гэмт хэргийн шинжтэй бол цагдаагийн байгууллагын шийдвэрээр шүүхийн шинжээч эмч хийнэ.


- 4.5. Нас барснаас хойш 24 цагийн дотор эмгэг судлалын шинжилгээнд хамруулна.
- 4.6. Эмгэг судлалын шинжилгээнд орох бүрэлдэхүүнийг магадлан хэлэлцэх зөвлөлийн дарга (нарийн бичиг) эсвэл эмчилгээ эрхэлсэн орлогч томилох ба эмгэг судлаач эмчээс гадна томилогдсон бусад холбогдох эмч, мэргэжилтнүүд оролцоно.
- 4.7. Эмгэг судлаач эмч эмнэлгийн бус нөхцөлд эндсэн эндэгдэлтэй холбоотой бүх баримттай танилцаж, эмгэг судлалын шинжилгээг хийж, шинжилгээний дүгнэлтийг хуанлийн 21 хоногийн дотор гаргаж, Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусламжийн хэлтсийн даргад хүргүүлнэ.

Тав. Эмнэлзүй, эмгэг судлалын хурал хийх

- 5.1. Эмгэг судлал болон шүүхийн шинжилгээний эцсийн онош, дүгнэлт гарснаас хойш ажлын 7 хоногийн дотор байгууллагад суурилсан эмнэлзүйн хурлыг сум өрхийн ЭМТ-үүд нь удирдах дээд байгууллагаас холбогдох төлөөлөл, эмгэг судлаач эмч, шүүхийн шинжээч эмчийг оролцуулан зохион байгуулна.
- 5.2. Эмнэлзүйн хурал хийхэд дараахь бичиг баримтыг бүрдүүлсэн байна.
  - Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр
  - 2 хүртэлх насны хүүхэд бол эхийн жирэмсний хяналтын карт
  - Хүүхдийн өвчний цогц менежментийн үзлэгийн маягт
  - Хүүхдийн диспансерийн хяналтын карт
  - Амбулаторийн карт, цахим бүртгэл, нөхцөл байдлын зураг
  - Эцэг, эх, асран хамгаалагч нарын өгүүлэмж
  - Хүүхдийн өсөлт, хөгжлийн хэмжилтийн бүртгэл
  - Шаардлагатай тохиолдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч байсан холбогдох бусад материалууд (яаралтай тусламжийн хуудас, төрөлтийн, нярайн болон өвчний түүхийн хуулбар)
  - Эмгэг судлалын болон шүүхийн шинжилгээний дүгнэлт
- 5.3. Эндэгдэл бүхий сум, өрх ЭМТ-үүд, хувийн хэвшлийн эмнэлэг нь өөрийн байгууллагад суурилсан эмнэлзүй, эмгэг судлалын хурлын удирдамж, зарыг гарган, хурал хийхээс ажлын 5 хоногийн өмнө шүүмж хийлгэх баримт материалуудыг хүүхдийн болон эх барих эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэнд нууцлалын зэргийг чанадлан хүргүүлсэн байна. ЭМГ-ын мэргэжилтнүүд нь тухайн тохиолдлын дагуу холбогдох мэдээллийг үндэслэн хуралд бэлтгэн ажлыг удирдлага аргагүйгээр ханган ажиллана.
- 5.4. Хурлаар эмнэлгийн бус нөхцөлд эндсэн эндэгдлийн шалтгаан, хожимдол, үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанарт үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмж гарсан байна.



Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны  
1.1 сарын 25 өдрийн 4/4 дугаар тушаалын  
гуравдугаар хавсралт



## МАГАДЛАН ХЭЛЭЛЦЭХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ГҮЙЦЭТГЭХ ЧИГ ҮҮРЭГ

Нэг. Магадлан хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүн

Зөвлөлийн дарга :

- Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга  
Нарийн бичгийн дарга :

- Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн (хүүхдийн эндэгдэл хэлэлцэх үед)
- Эх барих, эмэгтэйчүүдийн ерөнхий мэргэжилтэн (эрт нярайн эндэгдэл, амьгүй төрөлт хэлэлцэх үед)
- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн чанарын менежер(БОЭТ-д гарсан эндэгдлийг хэлэлцэх үед)

Гишүүд:

- БОЭТ-ийн эмчилгээ эрхэлсэн орлогч
- БОЭТ-ийн чанарын албаны дарга
- Үндсэн нарийн мэргэжлийн зөвлөх эмч нар
- ЭМГ-ын анхан шатны тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Сум, өрхийн ЭМТ-ийн дарга нар
- Тухайн сум өрхийн ЭМТ-ийн чанарын асуудал хариуцсан эмч, мэргэжилтэн,
- Статистикч их эмч,
- Шаардлагатай тохиолдолд холбогдох эмч, мэргэжилтнүүд

Хоёр. Магадлан хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүн, гүйцэтгэх чиг үүрэг

1. Зөвлөлийн дарга эндэгдлийн хурлыг удирдан зохион байгуулах, бэлтгэл ажил, шийдвэрт хяналт тавих,
2. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь эндэгдэлтэй холбоотой материалыг хүлээн авах, хурлын зар хүргүүлэх, хурал зохион байгуулах өрөө тасалгааг зохицуулах, тэмдэглэл хөтлөх, холбогдох байгууллагад мэдээ тайланг хүргүүлэх, байгууллагад суурилсан эмнэлзүй эмгэг судлалын хурлын бэлтгэл ажлыг хангуулах, аргагүйгээр хангах
3. Чанарын албаны дарга, менежер нь тусламж үйлчилгээний эрсдлийг үнэлэх, алдаанаас суралцах, дахин давтахаас сэргийлэх талаар санал оруулах, мэдээлэл, зөвлөмж бэлтгэх, тэмдэглэл хөтлөх
4. Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүд нь хэрэгжиж буй хууль тогтоомж, түүний

хэрэгжилтийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, тогтолцоотой холбоотой асуудлаар ЭМЯ-нд санал хүргүүлэх,

5. Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга, мэргэжилтэн нь эндэгдэлд хүргэсэн нийгэм, биологийн хүчин зүйлсийг үнэлэх, түүнийг таслан зогсооход салбар хоорондын уялдааг сайжруулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх санал гаргах, хэрэгжүүлэх,
6. Статистикч эмч нь анхан шатны бичиг баримт, бүртгэл мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавьж ажиллах,
7. Гишүүд нь хариуцсан ажлын чиглэлээр үнэлэлт, дүгнэлт өгч цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны зөвлөмжид санал өгөх, өмнөх хурлын шийдвэрийг биелүүлэх, хэрэгжилтийг хангаж, тайлагнах.
8. Байгууллагуудын удирдах ажилтнууд нь эндэгдлийн шалтгаан нөхцөлд нөлөөлж буй хүчин зүйлийг бууруулах, хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, өмнө гарсан шийдвэрийн үр дүнг тайлагнах
9. Тухайн тохиолдолтой холбоотой оролцож байгаа эмч, мэргэжилтнүүд тохиолдолд суурилан мэдлэг, ур чадвараа ахиулах, алдааг дахин давтагдахаас сэргийлэх
10. Үндсэн мэргэжлийн зөвлөх эмч нар мэргэжлийн зөвлөгөө өгөх, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх, үйл ажиллагааг сайжруулах санал оруулах үүрэгтэйгээр оролцоно.